



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

“Мандал женерал даатгал” ХХК-д эрх бүхий
албан тушаалтан томилохыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал женерал даатгал” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр Очирпүрэв овогтой Ганжолоо, Лувсандорж овогтой Болормаа, Ерөнхий нягтлан бодогчоор Ганбаатар овогтой Баярцэцэг нарыг тус тус томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг О.Ганжолоо, Л.Болормаа, Г.Баярцэцэг нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000567